



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 11 өдөр

Дугаар 848

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1, “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээ”-ний тухай Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрчим сүлжээ” ХХК-аас үнэ төлбөргүй шилжүүлсэн Зүүнхараа, Спирт Бал Бурам ХХК-ийн үйлдвэрийн үндсэн тэжээлийн бкВ-ын 3 км цахилгаан дамжуулах агаарын шугам, 520м кабель шугам болон бэлтгэл тэжээлийн бкВ-ын 2,8 км цахилгаан дамжуулах агаарын шугам, 500м кабель шугамын барилга угсралтын ажлын 2 нэрийн нийт 19,979,463.84 (арван есөн сая есөн зуун далан есөн мянга дөрвөн зуун жаран гурван төгрөг наян дөрвөн мөнгө) төгрөгийн балансын үнэ, 10,235,410.54 (арван сая хоёр зуун гучин таван мянга дөрвөн зуун арван төгрөг тавин дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Нямсамбуу нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Д.Дугаар

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2020 оны /дугаар сарын 28/-ны өдрийн  
7/д дугаар тогтоолын хавсралт

**"ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААЛТЫН  
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ (ш)	Балансын үнэ /төгрөг/	Хурумтлагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэгдэл өртөг /төгрөг/
1	110/35/6 кВ-ын Зүүнхараа дэд станцад суурилагдсан тоноглол, Ячейк №5, Самара	2006	1	7,478,750.00	5,235,125.00	2,243,625.00
2	110/35/6 кВ-ын Зүүнхараа дэд станцад суурилагдсан тоноглол, Ячейк №30, Самара	2012	1	12,500,713.84	5,000,285.54	7,500,428.30
				19,979,463.84	10,235,410.54	9,744,053.30
				(арван есөн сая есөн зуун далан есөн мянга дөрвөн зуун жаран гурван төгрөг наян дөрвөн мөнгө)	(арван сая хойр зуун гучин таван мянга дөрвөн зуун арван төгрөг тавин дөрвөн мөнгө)	(есөн сая долоон зуун дөчин дөрвөн мянга тавин гурван төгрөг гучин мөнгө)
					<b>НИЙТ ДҮН</b>	



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 749

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх заалт, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.б дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Говь-Алтай аймагт барьж, ашиглалтад оруулсан, 4,300,027,230.00 (дөрвөн тэрбум гурван зуун сая хорин долоон мянга хоёр зуун гучин) төгрөгийн өртөг бүхий “Усан спорт, чийрэгжүүлэлтийн төв”-ийн барилга байгууламжийг Говь-Алтай аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Биеийн тамир, спортын улсын хорооны дарга Ц.Шаравжамц, Говь-Алтай аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Л.Ганхуягт наарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Говь-Алтай аймагт бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгийн задаргаа, зориулалтыг харгалзан эзэмшигч байгууллагыг тогтоох асуудлыг шийдвэрлүүлэх;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайлан арга хэмжээ авах.д тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Д.Нарангэрэл

Д.НАРАНГЭРЭЛ

13201750